

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдох үер, зуд, салхи шуурга, ой, хээрийн түймэр зэрэг байгалын аюулын давтамж нэмэгдэхээс гадна урьдчилан тааварлашгүй аюул, сорилт бэрхшээл учирч, олон улсын хөл хориот хүн, малын гоц халдварт өвчний шинэ тохиолдлууд гарч, олон хүний амь нас эрсдэж, мал, амьтан ихээр хорогдож, эд хөрөнгө сүйрч, улс орны нийгэм, эдийн засагт их хэмжээний хохирол учирч байна. Тухайлбал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн тоо 2015 онтой харьцуулахад 2024 онд 4.8 дахин нэмэгдсэн. 2014-2024 онд нийт 50215 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 4491 хүн /КОВИД19-1815/ амь насаа алдаж, 991308 хүн /КОВИД19-989816/ өвчилж, гэмтэж бэртэн, 11.5 сая толгой мал, амьтан хорогдож, 544.3 тэрбум төгрөгийн шууд хохирол учирчээ.

Уур амьсгалын өөрчлөлтөөс бий болж буй шинэ нөхцөлд нийцэж амьдрах, дасан зохицох, олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, салбар дундын харилцан ажиллагаа, удирдлага, зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, гамшгийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар аливаа аюул, сорилт бэрхшээлийг урьдчилан тооцож, даван туулах, тэсэж гарах, сэргээн босгох чадавхтай нийгмийг төлөвшүүлэх, гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр чухлаар тавигдаж байна.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” - ийн 4.4.4.14 дэх дэд заалтад “Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулна” гэж, Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.3 дахь хэсгийн 20-д Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгасан.

УИХ-аас 2017 онд шинэчлэн баталсан Гамшгаас хамгаалах тухай хуульд 2020-2024 оны хооронд 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Тухайлбал, 2020 онд 134 хэм хэмжээ, 2021 онд 14 хэм хэмжээ, 2022 онд 8 хэм хэмжээ, 2023 онд 6 хэм хэмжээ, 2024 онд 1 хэм хэмжээнд нэмэлт, өөрчлөлт орсон байх тул Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийлгэсэн.

Үр дагаврын үнэлгээгээр тус хуулийн үндсэн нэр томьёоны тодорхойлолтуудыг олон улсын баримт бичиг, стандартад нийцүүлж оновчтой тодорхойлох, гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, хуулиар олгосон эрх, үүргийн давхцал, хийдлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэл,

хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшгаас хамгаалах улсын хяналт, гамшгийн зарлан мэдээлэл, гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний зохицуулалт, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг илүү тодорхой болгох шаардлагатай байна гэж үзсэн.

Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, нийгмийн баталгаа, удирдах албан тушаалтны бүрэн эрх, хариуцлагын талаарх зохицуулалтыг оновчтой болгох, хэрэгжилтийг хангах механизмыг цогцоор нь бүрдүүлэх, гамшгаас хамгаалах удирдлагын хийдэл, зөрчлийг залруулах замаар тус байгууллагын мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчим, эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.

Мөн Гамшгаас хамгаалах тухай хуулийг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, үндэсний хууль тогтоомжийн нийцэл, уялдаа холбоог сайжруулах, хуулийн бүтэц, хэлбэр, хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагад нийцүүлж боловсронгуй болгох, эрх зүйн эрэмбэ, хууль хэрэглээний тогтвортой байдал, хэрэгжилтийн найдвартай, баталгаат, үр дүнтэй байдлыг хангах хэрэгцээ, шаардлага үүссэн байна гэж дүгнэсэн.

Иймд Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хууль зүйн үндэслэл болон практик хэрэгцээ шаардлага, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний санал, дүгнэлт, зөвлөмжид үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулсан болно.

Тус хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар гарна:

- Гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтын давхардал, хийдэл арилж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, гамшгаас хамгаалах алба, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл, бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавх сайжирч, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр дүн нэмэгдэж, гамшгийн эрсдэл буурна;

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоод, сайн дурынхан, иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурласан гамшгаас хамгаалах тогтолцоо бүрдэнэ;

- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг, хариуцлага, оновчтой болж, салбар дундын хамтын ажиллагаа сайжрах, гамшгийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг иргэн, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэнэ;

- Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвөөс гадна олон улсын зээл, буцалтгүй тусламж, даатгал, бонд зэрэг олон эх үүсвэрээс бүрдүүлсэнээр гамшгийн улмаас улсын төсөвт ирэх ачаалал багасч, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

-Бүх нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бий болгож бэхжүүлэх эрх зүйн үндэс бүрдэнэ.

---oOo---

**БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙД**

Х.ГАНХУЯГ

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Б.ЭНХБАЯР

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” -ийн 4.4.4.14 дэх дэд заалтад “Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулна” гэж, Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.3 дахь хэсгийн 20-д Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгасан нь Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Дэлхийн дахинд улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээний тогтворгүй байдал, техник технологи, хотжилт, үйлдвэржилт, хүн амын төвлөрөл, аюултай бодисын хэрэглээнээс үүдсэн осол, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй төрөл бүрийн гамшиг, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний эрсдэл улам бүр нэмэгдэж байна.

Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдох үер, ган, зуд, салхи шуурга, хэт халалт, ой, хээрийн түймэр зэрэг байгалын аюулт үзэгдлийн давтамж нэмэгдэхээс гадна урьдчилан тааварлашгүй аюул учирч, олон улсын хөл хориот хүн, малын гоц халдварт өвчний шинэ тохиолдлууд гарч, олон хүний амь нас эрсдэж, мал, амьтан ихээр хорогдож, эд хөрөнгө сүйрч, улс орны

нийгэм, эдийн засагт их хэмжээний хохирол учирч байна. Тухайлбал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн тоо 2015 онтой харьцуулахад 2024 онд 4.8 дахин нэмэгдсэн. 2015-2024 онд нийт 45410 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 4330 хүн /Ковид-19 цар тахлын үед 1815/ амь насаа алдаж, 991071 хүн /Ковид-19 цар тахлын үед 989816/ өвчилж, гэмтэж бэртэн, 11.5 сая толгой мал, амьтан хорогдож, 1.8 их наяд төгрөгийн шууд хохирол учирсан.

Иймд уур амьсгалын өөрчлөлтөөс бий болж буй шинэ орчин нөхцөлд нийцэж амьдрах, дасан зохицох, даван туулах чадавхыг сайжруулах, олон нийтийн оролцоонд тулгуурлаж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, салбар дундын харилцан ажиллагаа, удирдлага, зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, гамшгийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар аливаа гамшиг, осол, аюулыг урьдчилан тооцож, сөрөн тэсвэрлэх, сэргээн босгох чадавхтай нийгмийг төлөвшүүлж, гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр чухлаар тавигдаж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хийсэн “Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”-д үндсэн нэр томъёоны тодорхойлолтууд олон улсын баримт бичиг, стандартад зарим талаар нийцээгүй, оновчтой тодорхойлоогүй, бусад хууль, тогтоомжид жигдрээгүй, гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалт, хуулиар олгосон эрх, үүргийн давхцал, хийдэл их, уялдаа холбоогүй, хуульчлах шаардлагагүй зохицуулалт их байгаагаас гадна зарим үйл ажиллагааны зохицуулалтууд хуулиар бус, эрх зүйн актаар зохицуулагдаж байгаа нь хууль зүйн эрэмбэ, хууль хэрэглээний тогтвортой байдал, хэрэгжилтийн найдвартай, баталгаат, үр дүнтэй байдалд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэсэн.

Тухайлбал, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсонтой холбогдуулан цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахтай холбоотой асуудлыг суурь хуулиар зохицуулах, түүнчлэн цар тахлын нөхцөл байдал гэнэт үүссэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуульд 2020-2021 онд оруулсан 5 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн улмаас үүссэн удирдлагын эрх, үүргийн давхардал, хийдэл, зөрчлийг засаж залруулах нь тухайн хуулийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагын нэг хэсэг¹ гэж үзсэн.

Тус тайланд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэл, хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, гамшгаас хамгаалах улсын хяналт, гамшгийн зарлан мэдээлэл, гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний зохицуулалт, хамрах хүрээ, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд засаг захиргаа,

¹ Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, 7 дахь тал

нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн удирдлага, иргэд, олон нийт, хувийн хэвшлийн оролцоо, хариуцлагыг илүү тодорхой болгох шаардлагатай байна гэж тусгасан.

Мөн Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, нийгмийн баталгаа, удирдах албан тушаалтны бүрэн эрх, үүрэг, хариуцлагын талаарх зохицуулалтыг оновчтой болгох, хэрэгжилтийг хангах механизмыг цогцоор нь бүрдүүлэх, хийдэл, зөрчлийг залруулах замаар тус байгууллагын мэргэжлийн, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчим, эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх шаардлагатай² гэж үзсэн.

Түүнчлэн Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр Гамшгаас хамгаалах тухай хуулийг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, үндэсний хууль тогтоомжийн нийцэл, уялдаа холбоог сайжруулах, хуулийн бүтэц, хэлбэр, хэл зүй, найруулгад тавигдах нийтлэг шаардлагаас гадна агуулгад тавигдах нийтлэг шаардлага, тухайлбал: “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх; тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан, хуулийн хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх; хуулийн зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх; бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол эш татах, тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх шаардлага”-д нийцүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн байна гэж дүгнэсэн³.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хууль⁴-ийн 24 дүгээр зүйлд заасан хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд уг хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгана:

1/ зарим нэр томъёоны тодорхойлолтыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, товч тодорхой, ойлгомжтой болгож, шаардлагатай нэр томъёог шинээр нэмж тодорхойлно;

2/ гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдийг олон улсын жишигт нийцүүлэн бүх нийтийн бэлэн байдлын зэргийг хасаж, байнгын бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдлын гэсэн хоёр зэрэгтэй болгож, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шаардлага, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгоно;

3/ гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцооны давхцал, хийдлийг арилгаж, удирдлага, байгууллага хоорондын чиг үүргийн уялдаа холбоог оновчтой болгон,

² Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, 193-206 дэх тал

³ Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, 208-209 дэх тал

⁴ 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

хуульчлах шаардлагагүй зохицуулалтыг хасаж, хуульчлах шаардлагатай, журмаар зохицуулж байгаа асуудлыг хуульд тусгана;

4/ гамшгаас хамгаалах олон нийт, иргэдийн сургалт, мэдээлэл, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, гамшгийн эрсдэлийн үнэлгээний тусгай зөвшөөрөл, түүний хэрэгжилт, хяналттай холбоотой чиг үүргийг хуулийн этгээд, тухайлбал төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гэрээгээр гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ;

5/ гамшгийн үед нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээ авах асуудлыг Засгийн газрын бүрэн эрхэд тусгаж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлтгэл, бэлэн байдал, хариуцлагын тогтолцоог оновчтой болгоно;

6/ онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдлыг хангахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгана;

7/ гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх, гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор онцгой байдлын байгууллагын салбар нэгжгүй суманд онцгой байдлын байгууллагын мэргэжлийн алба хаагчийг ажиллуулах, томоохон аж ахуйн нэгжид гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, улсын онц чухал болон стратегийн зориулалттай төрийн өмчит үйлдвэрийн газарт гэрээт нэгж болон гэрээт байцаагчийг ажиллуулах асуудлыг тусгана;

8/ гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтыг боловсронгуй болгох, түүний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төрөөс гарч буй үргүй зардлыг багасгах зохицуулалтыг нэмж тусгана;

9/ үндэсний хууль тогтоомжийн нийцэл, уялдаа холбоог сайжруулах олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх, зарим зүйл, хэсэг, заалтын уялдаа холбоог хангах, утга агуулгын хувьд оновчтой болгох, нэг мөр ойлгож хэрэглэх үүднээс нэмэлт оруулж, өөрчлөн найруулж, шаардлаггүй хэсэг, заалтыг хасна;

10/ хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн дараах үр дагавар гарна:

1/ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 35 хүртэлх хувьд нэмэлт, өөрчлөлт орно;

2/ Хуулийн нэр томъёоны тодорхойлолтууд товч тодорхой, ойлгомжтой болж, эрх зүйн зохицуулалтын уялдаа холбоо, хууль тогтоомжийн нийцэл, хэрэглээний тогтвортой байдал хангагдана.

3/ Гамшгаас хамгаалах удирдлага, зохицуулалтын давхардал, хийдэл арилж, гамшигтай тэмцэх, шуурхай хариу арга хэмжээ авах, хор уршгийг арилгах нэгдсэн зохион байгуулалт, салбар дундын зохицуулалт сайжирч, гамшгийн улмаас нийгэм, эдийн засагт учрах хохирол буурна;

4/ Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх үндэслэл, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, мөрдвөл зохих хэм хэмжээ тодорхой болж, төрөөс авч хэрэгжүүлэх зохицуулалт, зохион байгуулалтын хүндрэл, бэрхшээл арилна.

5/ Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сум бүрт онцгой байдлын байгууллагын 1 алба хаагч, улсын онц чухал болон стратегийн зориулалттай төрийн өмчит үйлдвэрийн газарт гэрээт нэгж болон гэрээт байцаагч ажилласнаар тухайн орон нутаг, байгууллагын гамшгаас хамгаалах удирдлага зохицуулалт, төлөвлөлт, бэлэн байдал, сургалт, сурталчилгааны үр дүн сайжирч, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоо нэмэгдэж, гамшгийн эрсдэл буурна;

6/ Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсвөөс гадна олон улсын зээл, буцалтгүй тусламж, даатгал, бонд зэрэг олон эх үүсвэрээс бүрдүүлсэнээр гамшгийн улмаас улсын төсөвт ирэх ачаалал багасч, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

7/ Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг, хариуцлага, оновчтой болж, салбар дундын хамтын ажиллагаа сайжирч, гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал дээшилж, бүх нийтийн оролцоонд тулгуурласан гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавх бүхий гамшгаас хамгаалах тогтолцоо бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын-ний өдөр

Улаанбаатар хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 4.1.25, 4.1.26, 4.1.27 дахь заалт:

“4.1.25. “нүүлгэн шилжүүлэх” гэж гамшгаас хамгаалах зорилгоор хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг аюулгүй орчинд шилжүүлэн байршуулах арга хэмжээг;

4.1.26. “гамшгаас хамгаалах алба” гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагааг эрхэлсэн салбарын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг түшиглэн байгуулсан орон тооны бус томилгоот нэгжийг;”

4.1.27. “гамшигтай тэмцэх чадавх” гэж гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, иргэдийн хүч хэрэгслээ ашиглан эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах чадавхыг;

2/ 8 дугаар зүйлийн 8.4, 8.5 дахь хэсэг, 8.5.1-8.5.3 дахь заалт

8.4. Уул, уурхайн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой байдлын байгууллага баталж, хяналт тавина.

8.5. Дараахь аж ахуйн нэгж гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй байж болно:

8.5.1. үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр явуулдаг;

8.5.2. ажлын байр, объектгүй;

8.5.3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1.1-т заасан бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч.

3/10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг:

“10.7. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээг тогтоох журмыг Засгийн газар батална.

4/ 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг

“11.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор өндөржүүлсэн байдлын зэрэгт шилжүүлнэ.

5/ 12 дугаар зүйлийн 12.4, 12.5 дахь хэсэг,

12.4.Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах болон аюулыг үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагч хяналт тавина.

12.5.Стратегийн болон улсын онц чухал объектод гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагчийг гэрээгээр ажиллуулж болох бөгөөд холбогдох зардлыг тухайн байгууллага хариуцна.

6/13 дугаар зүйлийн 13.3.6 дахь заалт, 13.6-13.10 дахь хэсэг:

13.3.6.сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын байгууллагад суралцагчийн сургалтыг тухайн шатны боловсролын сургалтын байгууллага;

13.6. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгжийн удирдлага, ажилтан, албан хаагч, иргэнд гамшгаас хамгаалах мэдлэг, дадлага олгох зорилгоор гамшгаас хамгаалах иж бүрэн болон гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургуулийг зохион байгуулна.

13.7.Гамшгаас хамгаалах иж бүрэн болон гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургуулийг аймаг, нийслэл, гамшгаас хамгаалах улсын албаны түвшинд Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүргийн түвшинд аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллага тус тус зохион байгуулна.

13.8.Гамшгаас хамгаалах иж бүрэн болон гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургуулийг зохион байгуулсан бол энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.4, 13.2.5-д заасан ангиллын сургалтыг зохион байгуулсанд тооцно.

13.9.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 13.3.2, 13.3.3, 13.3.4, 13.3.6, 13.3.7-д заасан гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.

13.10. Гамшгаас хамгаалах талаар олон нийтэд ойлголт, мэдлэг олгоход чиглэсэн мэдээлэл, сургалт, нэвтрүүлгийг Олон нийтийн радио, телевизээр улирал тутам, тогтоосон цагт нийтийн хүртээл болгоно.

7/ 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг

14.3.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардагдах мэдээ, мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авна.

8/ 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь хэсэг:

“19.4.Хүч хэрэгсэл дайчлан гаргах үед барилга байгууламж, газрын зориулалтыг түүний өмчлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр түр хугацаагаар өөрчилж болно.

19.5.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл болон эзэмшлийн эд хөрөнгө, бараа материал, газар, барилга байгууламжийг дайчилсан тохиолдолд энэ хуулийн 20.4-т заасан журмын дагуу зардлыг олгоно.

9/ 26 дугаар зүйлийн 26.1.9, 26.1.10 дахь заалт:

26.1.9.гамшгийн үед нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

26.1.10.энэ хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасан шийдвэр гарсан тохиолдолд гамшгийн нөлөөллийг бууруулах, хэвийн нөхцөлд оруулах зорилгоор жилийн батлагдсан төсвийн нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх;

28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалт

28.1.12.гамшгийн үед онцгой байдлын албан хаагчийн хэрэглэх тусгай зориулалтын хувцасны төрөл, стандарт, хэрэглэх зааврыг батлах.

10/ 29 дүгээр зүйлийн 29.1.20 дахь заалт

29.1.20.гамшигтай тэмцэх техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын хувцас хэрэгсэл, хүнсний болон шатахууны нөөц бүрдүүлэх.

11/ 32 дугаар зүйлийн 32.2.1 дэх заалт:

32.2.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийт, нөхөрлөл, сайн дурынхан, сууц өмчлөгчдийн холбоог татан оролцуулж хамтарч ажиллах, урамшуулал авах;

12/ 34 дүгээр зүйлийн 34.1.3, 34.1.4, 34.2.11 дэх заалт

34.1.3.нийтийн үйлдвэр, үйлчилгээ, онц чухал объект, томоохон барилга байгууламж эзэмшдэг, өмчилдөг аж ахуйн нэгж, байгууллага нь гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, нэгж томилж ажиллуулах;

34.1.4.гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх.

34.2.11.гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд дайчлагдан оролцсон, хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тусгаарлалтын дэглэмд байгаа ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах.

13/ 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт

35.1.6. хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд оролцох.

14/ 37 дугаар зүйлийн 37.2.9 дэх заалт

37.2.9.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед өөрийн өмчлөлийн барилга байгууламж, эд хөрөнгө, газрыг холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу хүн амд ашиглуулах;

15/ 42 дугаар зүйлийн 42.8.1 дэх заалт, 42.10 дахь хэсэг, 42.10.1 дэх заалт

42.8.1.онцгой байдлын байгууллагын бүсийн төвийн дарга хурандаа ба түүнээс дээш цэргийн цолтой байна.

42.10.Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын тамгын газарт онцгой байдлын байгууллагын нэг алба хаагчийг томилж ажиллуулна.

42.10.1.сумын Засаг даргын тамгын газарт томилогдон ажиллаж байгаа алба хаагчийн зардлыг төр хариуцна.

16/ 50 дугаар зүйлийн 50.15-50.18 дахь хэсэг

50.15.Онцгой байдлын байгууллагын захиалгаар гадаадын их, дээд сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлс болон ирэх, буцах нэг удаагийн тээврийн зардлыг төр хариуцна.

50.16.Гадаадын их, дээд сургуульд суралцагчид цалин хөлс олгох журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

50.17.Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

50.18.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга тогтооно.

17/ 51 дүгээр зүйлийн 51.5 дахь хэсэг, 51.6.1-51.6.3 дахь заалт, 51.7 дахь заалт:

51.5.гамшиг, ослын шинжлгүй, ахуйн дуудлагаар ажилласан томилгоот шуурхай бүлгийн задлыг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд хариуцан төлнө.

51.6.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн төсвөөс гадна дараахь эх үүсвэрээс санхүүжүүлж болно:

51.6.1.олон улсын зээл, буцалтгүй тусламж, хандив

51.6.2.бонд

51.6.3.даатгал

51.7.Энэ хуулийн 51.2, 51.5, 51.6-д заасан хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журмыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

2 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/ 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг

1.1.Энэ хуулийн зорилт нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах, шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, оролцогч талуудын эрх, үүрэг болон онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2/ 4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.6, 4.1.8, 4.1.10, 4.1.11, 4.1.13, 4.1.14, 4.1.19, 4.1.24 дэх заалт

4.1.1."гамшиг" гэж байгалийн аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн гамшигтай тэмцэх чадавхаас давсан хохирол учирч, нийгмийн хэвийн үйл ажиллагаа алдагдахыг;

4.1.2."байгалийн аюулт үзэгдэл" гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, хөрсний нуранги болон гулгалт болох, ой, хээрийн гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах зэргийг;

4.1.3."осол" гэж хүний буруутай болон санамсаргүй үйлдлээс хүний амь нас, эрүүл мэнд хохирох, уул уурхай, барилга байгууламж, дэд бүтэц эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох, объектын гал түймэр гарах зэргийг;

4.1.4.гамшгийн эрсдэл" гэж аюул, өртөх байдал, эмзэг байдал болон гамшигтай тэмцэх чадавхын харилцан хамаарлаар тодорхойлогдох хохирлын магадлалыг;

4.1.5."аюул" гэж байгалийн аюулт үзэгдэл, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, эдийн засаг, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг

4.1.6."эмзэг байдал" гэж хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчны аюулыг тэсвэрлэх байдлыг;

4.1.8."гамшгийн эрсдэлийг бууруулах" гэж гамшгийн эрсдэлийг үнэлж болзошгүй хохирлыг багасгах, шинэ эрсдэл бий болохоос сэргийлэх, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг;

4.1.10."эрэн хайх, аврах ажиллагаа" гэж хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг;

4.1.11."голомтын бүс" гэж эрэн хайх,аврах, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж буй объект, нутаг дэвсгэрийг;

4.1.13."хүч хэрэгсэл дайчлан гаргах" гэж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах, тэдгээрийн эд хөрөнгө, газрыг ашиглахыг;

4.1.14."хор уршиг" гэж гамшиг, аюулын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, мал, амьтан хорогдсон, эд хөрөнгө үрэгдсэн, дэд бүтэц эвдэрсэн, хүрээлэн буй орчинд нөлөөлсөн зэрэг сөрөг үр дагаврыг;

4.1.19. "гамшгийн онцгой нөхцөл байдал" гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, барилга байгууламж, дэд бүтцэд хохирол учруулсан буюу учруулахуйц байгалийн аюулт үзэгдэл, осол тохиолдсоныг;

4.1.24. "бэлэн байдал" гэж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулах чадавхыг;

3/ 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг:

7.5. Онцгой байдлын байгууллага гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд хяналт тавих бөгөөд энэхүү чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлж болно.

4/ 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:

8.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг улсын болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, гамшгаас хамгаалах алба, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд боловсруулж хэрэгжүүлнэ.

5/ 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.5 дахь заалт:

9.1.1. гамшгийн эрсдэлийн шалтгаан, нөхцөлийг арилгах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх;

9.1.5. хөгжлийн бодлого, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох.

6/ 10 дугаар зүйлийн 10.3.7 дахь заалт, 10.5 дахь хэсэг:

"10.3.7. гамшгаас хамгаалах салбар дундын харилцан ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах.

10.5. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өмчийн хэлбэрийг үл харгалзан мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна."

7/ 11 дүгээр зүйл:

11 дүгээр зүйл. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх

8/ 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг:

12.1. Гамшгаас хамгаалах хяналтыг төрийн хяналт, шалгалтын тухай хууль тогтоомжийн дагуу онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

12.3. Гамшгаас хамгаалах хяналтын улсын ерөнхий байцаагч нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга байх бөгөөд улсын ахлах байцаагч, байцаагчийг томилж, чөлөөлнө.

9/ 13 дугаар зүйлийн 13.2.3 дахь заалт:

“13.2.3.сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын байгууллагад суралцагчийн.”

10/ 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг

22.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед салбар дундын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.

11/ 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг

23.1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд Засгийн газар бодлого, стратегиар хангаж, онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохицуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн удирдлага зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

12/ 26 дугаар зүйлийн 26.1.5, 26.1.7 дахь заалт:

26.1.5.үүссэн гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол, шуурхай, хүртээмжтэй, мэдээлэх;

26.1.7.өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тогтоох, холбогдох хөрөнгийг шийдвэрлэх;

13/ 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.1, 27¹.1.2, 27¹.1.6 дахь заалт, 27¹.4, 27¹.5 дахь хэсэг

27¹.1.1.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед салбар дундын харилцан ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;

27¹.1.2.өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

27¹.1.6.шаардлагатай тохиолдолд онцгой комиссын шуурхай штабыг байгуулах, ажлын хэсгийг томилж ажиллуулах;

27¹.4.Онцгой комиссын шуурхай штаб, ажлын хэсгийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын, орон нутагт Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлнэ.

27¹.5.Улсын онцгой комисс нь өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын албатай байх бөгөөд түүний алба хаагчийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

14/ 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт:

29.1.3.гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах удирдамжийг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх;

15/ 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт:

30.1.2.гамшгаас хамгаалах болон дайчлан гаргасан хүч хэрэгслийг хуваарилах, оролцуулах;

16/ 34 дүгээр зүйлийн 34.2.8 дахь заалт:

34.2.8.гамшиг, гамшигийн онцгой нөхцөл байдлын үед өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газар, барилга байгууламж, эд хөрөнгө, техник хэрэгсэл, бараа материалыг холбогдох байгууллагын шийдвэрийн дагуу ашиглуулах;

17/ 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг:

35.1.Төрийн бус байгууллага нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2.1, 34.2.2, 34.2.7, 34.2.8, 34.2.10 -т зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй оролцоно:

18/ 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалт:

37.1.3.гамшигт нэрвэгдсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагатай тусламж, дэмжлэг авах;

19/ 42 дугаар зүйлийн 42.7 дахь хэсэг:

42.7.Монгол Улсын аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг харгалзан Онцгой байдлын байгууллагын бүсийн төвийг байгуулж, гамшигийн үеийн удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулна.

3 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “зохион байгуулах” гэсний өмнө “удирдан” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.17 дахь заалтын “сум” гэсний өмнө “аймаг, нийслэл” гэж, 4.1.18 дахь заалтын “иргэдийг” гэсний өмнө “гамшигтай тэмцэх анхан шатны багаж, тусгай зориулалтын хувцас, хэрэгслэлээр хангагдсан” гэж, долдугаар бүлгийн “ХУУЛИЙН ЭТГЭЭД,” гэсний дараа “САЙН ДУРЫН ХЭСЭГ,” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “сэргээн осгох,” гэсний дараа “хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх,” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “тэмцэх” гэсний дараа “, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох” гэж, 13 дугаар зүйлийн “сургалт” гэсний дараа “, сурталчилгаа” гэж, “зохион байгуулах” гэсний дараа “мэдээллээр хангах” гэж, 13.3.2 дахь заалтын “албан тушаалтан,” гэсний дараа “баг, хорооны Засаг дарга” гэж, гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 14.2.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.5 дахь заалт, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтын “аюулт үзэгдэл,” гэсний өмнө “байгалийн” гэж, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “нутаг дэвсгэр” гэсний дараа “, стратегийн ач холбогдол бүхий” гэж, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн “зардлыг” гэсний дараа “ иргэн,” гэж, 22 дугаар зүйлийн 22.7 дахь хэсгийн “Сум, “ гэсний дараа “дүүрэг,” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.8 дахь заалтын “бэлэн байдлын” гэсний өмнө “өндөржүүлсэн” гэж, 32 дугаар зүйлийн 32.1.13 дахь заалтын “ удирдах” гэсний дараа “болон гүйцэтгэх” гэж, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтын “салбарын хэмжээнд” гэсний дараа “гамшигийн эрсдэлийг бууруулах” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтын “ажиллах,” гэсний дараа “сургалт,” гэж, 34.2.5 дахь заалтын “эрсдэлийн” гэсний дараа “ерөнхий үнэлгээ хийх, үйл ажиллагааны

онцлогтоо нийцүүлэн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан” гэж, 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалтын “үйл ажиллагаанд” гэсний дараа энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2.1, 34.2.2, 34.2.7, 34.2.8, 34.2.10, 34.2.11-т зааснаас гадна” гэж, “36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтын “багаж,” гэсний дараа “тусгай зориулалтын хувцас,” гэж, 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн “тэргүүн дэд” гэсний өмнө “дарга,” гэж, 42.9 дэх хэсгийн “төрөл” гэсний өмнө “тоо,” гэж, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “Цэргийн албаны тухай хууль” гэсний өмнө “Төрийн албаны тухай хууль” гэж, 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “арга хэмжээг” гэсний өмнө “гамшгаас хамгаалах” гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 дэх заалт, 4.1.15 дахь заалтын “гамшгийн” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.3.6 дахь заалтын “гамшгийн үед” гэснийг, 10.4 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1.6 дахь заалтын “гамшгаас хамгаалах” гэснийг, 10.4.1 дэх заалтын “гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх,” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 24.1-д заасан” гэснийг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “болон цэргийн жинхэнэ алба хаасан”, “хуулийн этгээд, эрэлч нохой,” гэснийг, 27¹ дүгээр зүйлийн 27¹.2 дахь хэсгийн “27¹.1.8” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтын “удирдан” гэснийг, 28.1.5 дахь заалтын “салбар хоорондын харилцан ажиллагааны төлөвлөгөө,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.2.6 дахь заалтын “орон нутгийн” гэснийг, 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсгийн “журам, хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн таних тэмдгийн загвар, хэрэглэх” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтын “гамшгаас” гэснийг “гамшгийн эрсдэлийг бууруулах” гэж, 4.1.9 дэх заалтын “олон нийтэд” гэснийг “гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор хүн амд” гэж, 4.1.20 дахь заалтын “аюулт үзэгдэл, ослын хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас” гэснийг “аюулаас” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтын “иргэдийн” гэснийг “бүх нийтийн” гэж, 6 дугаар зүйлийн “Гамшгийн өмнөх” гэснийг “гамшгаас урьдчилан сэргийлэх” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хуулийн этгээд” гэснийг “аж ахуйн нэгж” гэж, “хийнэ” гэснийг “хийлгэнэ” гэж, 7.3.1 дэх хэсгийн “үнэлгээний” гэснийг “үнэлгээ хийх” гэж, 10 дугаар зүйлийн “бэлэн байдлыг хангах” гэснийг “бэлэн байдал” гэж, 10.1.1 дэх заалт, 10.3 дахь хэсгийн “өдөр тутмын” гэснийг “байнгын” гэж, 10.2 дахь хэсгийн “гамшгийн гэснийг гамшгаас хамгаалах” гэж, 10.4.12 дахь заалтын “хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагад чиглэл болгох,” гэснийг “хэрэгжүүлэх,” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “гамшгаас хамгаалах” гэснийг “өндөржүүлсэн” гэж, 11.5 дахь хэсгийн “13.3.1” гэснийг “13.6” гэж, “сургалтын” гэснийг “дадлага, сургуулийн” гэж, 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь заалтын “мэргэжлийн ангийн,” гэснийг “мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн,” гэж, 13.3.7 дахь заалтын “эрх бүхий албан тушаалтан” гэснийг “удирдлага” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, 51.4 дэх хэсгийн “хуулийн этгээд” гэснийг “аж ахуйн нэгж” гэж, 22 дугаар зүйлийн 22.8 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэг, 34.2 дахь хэсгийн “хуулийн этгээд” гэснийг “аж ахуйн нэгж, байгууллага” гэж, 26 дугаар зүйлийн 26.1.7 дахь заалтын “Улсын онцгой комиссын саналын дагуу гамшгаас хамгаалах” гэснийг “өндөржүүлсэн” гэж, 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.4 дэх заалтын “гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх” гэснийг “холбогдох” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэх заалтын “орон нутгийн” гэснийг “улсын хэмжээнд” гэж, 29.1.7 дахь заалтын “шаардагдах” гэснийг “энэ хуулийн 24.1-д заасан” гэж, “дайчлан” гэснийг “татан” гэж, 29.1.11 дэх заалтын “гамшгийн” гэснийг “улсын” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын “гамшгаас хамгаалах албаны” гэснийг “онцгой байдлын байгууллагын” гэж, 30.1.5 дахь заалтын

“бэлэн байдлын” гэснийг “бэлэн байдлыг хангах” гэж, 30.1.12 дахь заалтын “гамшгаас хамгаалах” гэснийг “албаны” гэж, 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтын “гамшгаас хамгаалах” гэснийг “гамшгийн” гэж, 32.1.7 дахь заалтын “гамшгийн эрсдэлийг бууруулах” гэснийг “гамшгаас хамгаалах үйл” гэж, 32.1.9 дэх заалтын “татан оролцуулах” гэснийг “дайчлан гаргах ажлыг зохион байгуулах” гэж, 32.2 дахь хэсгийн “эрхийг” гэснийг “эрхээс гадна дараахь эрхийг” гэж, 33 дугаар зүйлийн 33.1.7 дахь заалтын “татан оролцуулах” гэснийг “дайчлан гаргах” гэж, 33.1.12 дахь заалтын арга хэмжээний санал боловсруулах” гэснийг “арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх” гэж, 34 дүгээр зүйлийн 34.2.10 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.2.7 дахь заалтын “гал түймрийн улсын хяналтын байцаагч” гэснийг “гал түймрийн хяналтын улсын байцаагч” гэж, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийн “даргын” гэснийг “ дарга, тэргүүн дэд болон дэд даргын” гэж, 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсгийн “Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч” гэснийг “Гамшгаас хамгаалах болон гал түймрийн хяналтын улсын байцаагч” гэж, 50 дугаар зүйлийн 50.9 дэх хэсгийн “30” гэснийг “40” гэж, 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсгийн “1,0 хувиас” гэснийг “3.0 хувиас” гэж, “1.5 хувиас” гэснийг “5.0 хувиас” гэж тус тус өөрчилсүгэй.

6 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 9.1.3 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.3, 27¹.1.3, 27¹.1.7, 27¹.1.8, 27¹.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.14 дэх заалт, 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

.....